



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо 2025.04.30

Дугаар 01

Улаанбаатар хот

Хэзээ: 2025.04.30 ний өдөр 15 цагт

Хаана: “Баянгол ресторан”-ний банкет танхимд / цахим facebook live/

Хөтлөгч: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Баянгол зочид буудал Хувьцаат Компанийн 2025 оны 4-р сарын 30ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит 32-р хурал эхлэхэд бэлэн боллоо.

Хурлыг нээн, хурлын бэлтгэл ажлын талаар танилцуулна уу хэмээн ТУЗ-ын гишүүн Цэрэнчимэг таныг урьа.

ТУЗ-н гишүүн: З.Цэрэнчимэг:

Сайн байцгаана уу хувьцаа эзэмшигчидээ. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Баянгол зочид буудал үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Баянгол зочид буудал ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Цахим хэлбэрээр эхлэхэд бэлэн болоод байна.

Тус компанийн ТУЗ 2025 оны 03 сарын 17-ний өдөр хуралдаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 30 ний өдрийн 15 цагт өөрийн байранд цахимаар зохион байгуулахаар шийдвэрлэж ТУЗ-ийн тогтоол баталгаажуулсан. Уг тогтоолд хурлаар хэлэлцэх асуудлыг баталж хурал оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг тогтоож хурлын мэдэгдэлд олон нийтэд зарлах өдрүүд, хурлын баримт бичгийн хүргүүлэх өдрийг товлож санал хураах хуудсны загварыг баталгаажуулж тооллогын комиссын бүрэлдэхүүнийг сонгож хурал зохион байгуулах комиссын даргаар миний бие томилогдсон.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зардан хуралдуулах туай ТУЗ-ийн шийдвэрийг хавсралт материалуудын хамт СЗХ, МХБ-д хүргүүлж өөрийн цахим хаягт байршуулж хувьцаа эзэмшигчдийг хурлын баримт бичигтэй танилцах боломжийг олгосон.

Хурал зохион байгуулах комисс бэлтгэл ажлын хүрээнд ТУЗ-с батласан зар хүргэх загварын дагуу хурлын зарыг 3 сарын 24, 4 сарын 08-д Өдрийн сонин, Монголын мэдээ сонин С телевизэр тус бүр 2 удаа хувьцаа эзэмшигчдэд хүргэсэн..

Мөн хуралд оролцох эрх бүхий гишүүдийн жагсаалтыг ҮЦТТХА-с 4 сарын 10-р гаргуулж авсан.

Хурлаар хэлэлцэх хурлын материалын танилцуулгыг МХБ-н цахим хуудасд байрлуулж мөн өөрийн info@Bayangolhotel.mn хаягт байршуулж хувьцаа эзэмшигчдэд танилцах

боломжийг олгосон. Мөн компанийн удирдлагын багтай хамтран хийх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажилллаа. Ээлжит хурлыг зохион явуулахаар компанийн ТУЗ-н гишүүд Удирдлагын баг тооллогын комисс оролцож хурлын дэгийн дагуу ТУЗ-н дарга Аюуш удирдан явуулна. Хурлын үйл ажилагааг Баянгол цахим хуудсаар дамжуулна. Ингээд хуралдаа идэвхтэй оролцохыг нийт гишүүддэ хүргэе

Хөтлөгч: Тооллогын комиссын гишүүн Д.Удвал хуралд оролцох гишүүдийн ирцийг танилцуулах болно

Удвал : Баянгол зочид буудал ХК-н тооллогын комисс хурлын ирцийг танилцуулж байна. Баянгол зочид буудал ХК-н хувьцаа эзэмшигчдийн 32-р хуралд саналын эрхтэй 381,133 ширхэг хувьцаа эзэмшсэн 1051 хувь нийлүүлэгчдээс 342811 ширхэг хувьцаа эзэмшсэн хувь нийлүүлэгчид саналаа ирүүлсэн бөгөөд нийт хувьцааны 89,95% төлөөлж байгаа тул компанийн тухай хуулийн 69,1-р зүйл компанийн дүрмийн 7.4 зүйлийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөр тооцож байгааг мэдэгдэж байна.

Хөтлөгч : Ийнхүү хурлын ирц бүрдсэн байгаа тул хувьцаа эзэмшигчдийн хэрлыг эхлүүлж хурлыг дэгийг танилцуулна уу хэмээн ТУЗ дарга Аюун таныг урьа

Аюуш: Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн амар амгаланг эрье. Сая тооллогын комисс танилцуулснаар хурлын ирц 89,95% бол тул компаний тухай хуулийн 69 дүрмийн 7,4 заалтын дагуу хүчин төгөлдөр болсон тул хурлыг эхлүүлэе. Хурлын дэгийг хурал хуралдуулах тухай ТУЗ-н шийдвэрээр баталсанг танилцуулъя. Хуралд хэрхэн бэлдсэн, тооллогын комиссын тогтоолыг сонссон. Одоо компанийн үйл ажиллагааны тухай болон санхүүгийн үйл ажиллаганы тухай товч мэдээллийг хийнэ. Дараа нь үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн товч дүгнэлт, ТУЗ-н төсөв, ирсэн асуултыг танилцуулж түүнд хариулт өгнө. Нэг харулт 10-15 минут, тооллогын комисс саналын хуудсыг тоолж мэдэгдэнэ. Төгсгөлд хурлаас гарах тогтоолын ТУЗ-н гишүүн уншиж танилцуулна.

Хөтлөгч: Үйл ажиллагааны талаар Ерөнхий менежер Батцэнгэл танилцуулна.

Батцэнгэл: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Баянгол ХК нь 1964 оноос үйл ажиллагаагаа эрхэлсэн энэ онд 60 жилийн ойгоо тэмдэглэсэн ойн жил байлаа. Тус компани хоол үйлдвэрлэл, зочид буудлын чиглэлээр үндсэн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд 40-400 хүний багтаамжтай Баянгол, МНӨ, WH гэсэн 3 ресторан, 350 зочин хүлээн авах чадалтай 204 өрөө бүхий зочид буудлын үйл ажиллагааг явуулж байна. Зочлох үйлчилгээний анхдаг байгууллага 1991 онд анхны хувьцаат компани, олон улсын АА сүлжээний менежментийг нэвтрүүлсэн олон улсын экспертийг ажиллуулсан. 1964 оноос өнөөг хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж зочлох үйлчилгээний анхдагчаар түүчээлж явж байгаа байгууллага болно. Манай байгууллага 2003 онд анхны 4 одтой зочид буудал болсон мөн брэндийн бүтээгдэхүүнээ патентжуулж тухайн нэртйг бүтээгдэхүүнүүдээрэ үйлчилж байгаа. 2019 онооч чанарын менежементийн тогтолцооны ISO9001 -г нэвтрүүлснээрээ салбартаа анхдагч нь болсон. 2019 онд ISO-г батламжлуулж 2024 онд дахин батламжлуулалтанд

орсноороо итгэмжлэлээ авсан . Үйлчлүүлэгч хэрэгчдийн хүсэл сонирхолд нийцүүлэн үсчин гоо сайхан саун фитнес -н үйлчилгээг явуулж байна. Тус байгууллага нь үйлчилгээний 7 албанд 100 гаран ажиллагсад, 130 орчим ахмад, 300 гаруй харилцагч нартай тогтмол харьцаж байна.Зочдоо дээдлэн зочлохуйн үйлчилгээний салбарт олон талаараа анхдагч болж ирсэн бөгөөд тэргүүлэгч чиглэлээ барьж гадаад дотоодын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж чадварлаг хамт олныг бүрдүүлэн орчин үеийн дэвшилтэт техникналогийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж олон улсын стандарт болон үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжинд нийцсэн Баянгол брэндийн үйлчилгээг бий болгохоор алсын хараагаа тодорхойлож зочдын тав тухтай орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж , туршлагатай мэргэшсэн ажилтныг бэлтгэж буудлынхаа ор ашиглалтыг бууруулахгүй орлогын өмнөх жилүүдээсээ бууруулахгүйгээр ажиллах зорилтыг тавьж ажиллаж байна.

Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхээр 2024 онд 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр зочиддоо үйлчилжээ. 2024 оныг хөрөнгө оруулалтын жил болгож ажиллахдаа буудлын тохижилтонд тэрбум 300 мянга орчим төгрөг, галын дохиолол,дотоод хяналтын систем , автомашин , хөгжим, агл тогооны тоног төхөөрөмжүүдэд 430 гаруй сая төгрөг, Барилгын их засвар гадна тохиожолт урсгал засваруудад 280 орчим сая төгрөгийн зарцуулалтуудыг хийсэн.Ажиллагсадын тав тухтай орчныг бүрдүүлэн ажилласан байна. Хүний нөөцийн үйл ажиллагааг дэмжин төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулах, дотоод гадаадын олон улсын түвшний сургалтуудад хамруулж ажлын байрыг тогтвортой хадгалж ирсэн.

2024 онд 31696 зочинд зочид буудлын ор хоногоор, 25253 зочинд хоол ундаагаар үйлчилсэн. Бид 2025 оныг Үйлчилгээний чанар стандартын жил болгон зарлаж үйл ажиллагаа явуулж байна.

Хөтлөгч: 2024 оны санхүүгийн үзүүлэлтийг Ерөнхий нябо С.Алтантуяа танилцуулна.

С.Алтантуяа: Компаний санхүүгийн үзүүлэлтийн товч танилцуулга хийе.

2024 онд борлуулалтын орлого 11 тэр бум төгрөгт хүрсэн энэ нь 2023 онтой харьцуулвал 20% өсөлттэй байна Энэхүү орлогын 50.2% -г буудлын орлого, 40.8 хувийг рестораны орлого, 10% бусад орлого эзэлж байна. Буудлын орлогыг өмнөх онтой харьцуулвал 1,1 тэр бумд хүрч 26%-н өсөлттэй, рестораны орлого 406 сая-р буюу 10% өсөлттэй гарсан. Энэхүү борлуулалтын орлогын энэхүү өсөлт нийт хөрөнгийг 42,6 тэрбум буюу өмнөх онтой харьцуулахад 9% өсөлтөнд хүргэсэн байна. Цэвэр ашиг 3,7 тэрбум-д хүрч 31% өсөлттэй , эздийн өмч 40,7 тэрбум хүрч 9,8% өсөлттэй байна. Харин зардал 2024 онд 6,7 тэрбум буюу өмнөх онтой харьцуулахад 8% өсөлттэй гарсан. Нийт зардлын 64,4%-г түүхий эд материал, цалин хөлс 22% ашиглалт болон үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь 2,2% буюу 140 сая төгрөг бусад зардал 20% өсөлттэй буюу 17 тэрбумд хүрсэн байна.

2024 онд татварт 1,9 тэрбум-ыг төлсөн үүний 37,3%-г нэмэгдсэн өртөгийн албан татвар, 10% нийслэл хотын албан татвар, 22%-г аж ахуй нэгжийн албан татвар, 16,3% НДШ,

9,4% цалин хөлс ХАОАТ, 3,3%-г үл хөдлөх хөрөнгийн албан татварт, 1,6%-г газрын татварт тус тус төлсөн.

Хөтлөгч: Компанийн засаглал, 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, ноогдол ашиг хуваарилсан тухай шийдвэрийг ТУЗ-н дарга Аюуш тайлагнана

Аюуш: 2022 оны 3 сарын 23-ний өдрийн Санхүүгийн зохицуулах хорооны 145 тогтоолоор Монголын компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан байгаа. Бид энэ шинэчлэн батлагдсан кодекс-д нийцүүлэн компанийн засаглалын дотоод журмуудыг 2022.06.28-ний өдрийн хурлаас компанийн засаглалын кодекст багсан бүх журмыг баталсан. Үүний дотор 01 тогтоолоор ТУЗ-н үйл ажиллагааны журмыг баталсан. Баталсан журмуудын хүрээнд засаглалыг сайжруулах, дагаж мөрдөх үйл ажиллагааг баритлан ажиллаж ирсэн. Үүний дотор ТУЗ-н үйл ажиллагааны журмын дагуу ТУЗ үйл ажиллагаа явуулсан. Мөн ил тод байдалын журмын дагуу тухай бүр мэдээлэх мэдээлэл, тогтмол мэдээлэх мэдээлэлийг СЗХ, Хөрөнгийн бирж, өөрийн компанийн цахим хуудаст байршуулж тогтмол мэдээлж ирсэн. ТУЗ нь тайлант хугацаанд 8 удаа хуралдаж 8 тогтоол 6 хурлын тэмдэглэл гарсан Үүнд:

2023 оны үйл ажиллагаанд өгөх дүгнэлт

- ХЭХ ээлжит хурлыг хуралдуулах
- Компанийн бизнес болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батласан
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд дүгнэлт өгч цаашид сунгах тухай шийдвэр
- Аудитын компани сонгох
- Ноогдол ашиг хуваарилах
- 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг батлах
- ТУЗ-н сургалт зохион байгуулсан
- СЗХ-с Компанийн засаглалыг дүгнэдэг журам нэвтэрсэн энэ дүгнэлтээр манай компани 83,3% авсан. Энэ нь манай компани эхний 20-д багтаж байгаа.

Ноогдол ашгийн талаар мэдээлэл өгье. 2020, 2021 онуудад Ковид цар тахлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа эрс хумигдаж компанийн ашиг гараагүй учраас компанийн ноогдол ашиг хуваарилах шийдвэр гараагүй

2022 онд нэгж хувьцаанд 300₮, 2023 онд 300₮, 2024 онд нэгж хувьцаанд 330₮ олгохоор шийдвэрлэсэн. 2025 оны 02 сарын 18-ний өдрийн 02 тогтоолоор нэгж хувьцаанд 330₮ олгохоор шийдвэр гарсан. Энэ шийдвэрийг танилцуулъя

2025 оны ХЭ-н ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр ноогдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийг өдрийг тогтоохоор шийдсэн. 2025.05.01-ний өдрөөс ноогдол ашгийг хуваарилаж эхлэх. Компани дээрээс ноогдол ашгаа авах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн дансанд мөнгийг шилжүүлэх, үлдсэн хувьцааг ҮЦТХТ тэй гэрээ байгуулан ноогдол ашгийг шилжүүлнэ. Та бүхэн өөрсдийн харилцдаг брокерийн пүүсүүдээр дамжуулан ҮЦТХТ дамжуулан авах боломжтойг мэдээлье. Мөн өнгөрсөн онд хувьцааны арилжаа хэрхэн явсныг танилцуулъя. Хувьцааны 90% томоохон

хувьцаа эзэмшигчид төвлөрсөн байдаг тул арилжааны идэвхи их биш байдаг. Өнгөрсөн онд 16,212ш хувьцаа арилжаалагдсан. Зах зээлийн дундаж ханш 36,518₮ байсан нийт 592 сая төгрөгийн арилжаа хийгдсэн.

Санхүүгийн тайланд FISCAL АУДИТ ХХК хөндлөнгийн шалгалт хийсэн. Энэ компани 3 сарын 27 ний өдөр дүгнэлтээ өгсөн. Энэ дүгнэлтэнд тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СЗХ-с гаргасан журмын дагуу үнэн зөв бодитой тайлагнасан байна. Гэсэн дүгнэлт гаргаж манай санхүүгийн тайланд хязгаарлалтгүй дүгнэлт өгсөн. Бид цахим хуудсанд санхүүгийн бүх мэдээллийг оруулсан тэндээс та бүхэн танилцаж болно.

Хөтлөгч: info2bayangolhotel.mn -д ирсэн асуултыг танилцуулъя

1. 35 хувьцаа эзэмшигч Аюурзана - “ Үйлчилгээний салбарт хүний нөөцийн хомсдол үүсэн энэ нөхцөл Баянгол зочид буудал хүний нөөцөө хэрхэн бүрдүүлж байгаа вэ?
2. 50 хувьцаа эзэмшигч Гарамханд - 2024 оны ноогдол ашгийг хэзээ өгөх вэ

Х.Цэндбаяр: Бид мэргэжлийн сургуулиудтай хамтран оюутнуудад цагаар болон дадлагаар ажиллах боломжийг олгож ирээдүйн нөөцөө бүрдүүлж байна.

Баянголзочид буудал ХК нь 2025 оны 02 сарын 18-ний өдрийн ТУЗ-н 02 тогтоолоор 2025 оны 04 сарын 30-с эхлэн олгохоор шийдсэний дагуу брокерын пүүсүүдтэй гэрээгээ байгуулахн ноогдол ашгийг хуваарилах ажилдаа ороод явж байна.

Хөтлөгч: ТУЗ-н дарга Аюуш таныг урьж байна.

Аюуш: Хурлаар танилцуулах асуудал дууслаа хувьцаа эзэмшигчээс ирсэн асуултанд хариуллаа. Тооллогын комисс ажилдаа орно уу

Хөтлөгч: Тооллогын комиссын дарга С.Алтантуяа та тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна уу

С.Алтантуяа: Баянгол зочид буудал ХК-н ХЭХ-н тооллогын комиссын тогтоол 2025 . 04 . 30

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

1. Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт 63 дугаар зүйлийн 63.5 заалт, 67 дугаар зүйлийн 3.8 заалтыг үндэслэн тогтоох нь . Компаний 2024 оны үйл ажиллагаа санхүүгийн тайлагийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэх батлах асуудлаар нийт өгсөн саналын 343222 санал үүнээс татгалзсан, түтгэлзсэн байхгүй, хүчингүй-70 байхгүй зөвшөөрсөн 343152 санал өгсөн нь нийт саналын 99,98%-н саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон
2. Компанийн ТУЗ-н зардлын төсвийг батлах асуудлаар нийт өгсөн санал 342811, үүнээс татгалзсан түтгэлзсэн байхгүй зөвшөөрсөн 342811 санал өгсөн нь нийт саналын 100%-н саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсныг мэдэгдсэгүй

Комиссын дарга С.Алтантуяа

Хөтлөгч: Хурлаас гарсан тогтоолын ТУЗ-н дарга Аюуш танилцуулна.

Аюуш: Нэг асуудал орхигдсон байна. Энэ хурлаар 2 асуудал хэлэлцэх ёстой

1. Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ дүгнэлтийг батлах
2. ТУЗ-н төсвийг батлах

ТУЗ-н дүгнэлт :Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг дүгнэхэд тавьсан зорилгоо биелүүлсэн санхүүгийн тайлан санхүү эдийн засгий байдлыг бодитой тусгасан гэж үзэж Гүйцэтгэх удирдлага Х.Цэндбаяртай онцгой нөхцөлт гэрээг сунгахыг зөвшөөрсөн.

ТУЗ-н төсөвт зөвхөн цалинг оруулдаг. Хурлын зардлыг компанийн үйл ажиллагааны зардалд тооцдог өөр зардал ордоггүй. ТУЗ-н зардал: жилийн дүнгээр цалин 46,8 сая ндш 3,9 сая төгрөг нийтдээ 50,7 сая төгрөгөөр баталж байна.

Хурлаас гарах тогтоолыг танилцуулаад хурлыг хаалаа.

ХУРЛЫН ДАРГА:

ПРОТОКОЛ БИЧСЭН:



Б.АЮУШ

Д.ОЮУНЧИМЭГ

Д.ГАНЧИМЭГ